



CORPUS SCRIPTORUM

TOMUS I

ЦЭНДИЙН БАТТУЛГА

МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА  
ДУРСГАЛУУД

Тэргүүн дэвтэр

УЛААНБААТАР  
2005



## CORPUS SCRIPTORUM

---

### TOMUS I

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ  
ТҮРЭГ СУДЛАЛЫН ТӨВ

ЦЭНДИЙН БАТТУЛГА

# МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛУУД

Тэргүүн дэвтэр

Эрхилэн нийтлүүлсэн профессор Ц.Шагдарсүрэн

УЛААНБААТАР  
2005

DDC  
494.23  
Б-33

## ЦЭНДИЙН БАТТУЛГА

Монголын руни бичгийн бага дурсгалууд  
Хэвлэлийн эхийг цахим бичүүрт бэлтгэсэн Ц. Баттулга  
ADMON ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN 99929-0-419-4

©2005, ЦЭНДИЙН БАТТУЛГА

## CORPUS SCRIPTORUM цувралын тухайд

МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Түрэг судлалын төв (тэнхим) Монгол нутгаас олдсон эртний үсэг бичиг болоод монголчуудын хэрэглэж асан үсэг бичтийн хосгүй дурсгалуудын судалгааг нийтийн хүргээл болгох, ер үсэг бичгийн судлалыг хөхиулэн дэмжих зорилгоор **CORPUS SCRIPTORUM** (Үсэг бичгийн чуулган) хэмээх цувралыг эрхилэн гаргаж байх болно.

## МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛУУД номын тухайд

Монгол нутаг руни үсэг бичгээрээ нэн алдартай, тиймээс ч уг үсэг бичгийн дурсгалыг гадаад, дотоодын эрдэмтэд судлан шинжилж олон арван бүтээл түүрвийжээ. Тэдгэр судалгаа бүтээл Монголын руни бичгийн сонгодог дурсгалууд болох Билгэ хаан, Келтигин, Туньюокук нарын зэрэг томоохон гэрэлт хөшөөний бичээсийг гол төлөв уншиж орчуулан судлахад чиглэгдэж байжээ.

Харин ганц хоёр буюу нэжгээд мөрөөс бүтэх “бага бичээс”-ийг тухайлан судалсан нь харьцангуй цөөн ажээ.

Ийм учраас “*Монголын руни бичгийн бага дурсгалууд*”-ыг турван дэвтэр болгон хэвлэн нийтлэж судалгааны эргэлтэд оруулахыг зорьж буй билээ.

## МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛУУД, Тэргүүн дэвтэр-т

-манай эрдэмтдийн түүрвисан руни бичгийн холбогдолт ном зохиолд урьд өмнө хэвлэгдэж байгаагүй,

- судалгааны эргэлтэд орсон ч алдаа мадаг ихтэй,
- шинээр олдсон гэсэн үндсэн турван шалгуурыг баримтлан энэ удаад руни бичгийн 12 бага дурсгал, бичээсийг сонгон орууллаа.

Тэдгээр 12 бичээс тус бүрийн эхийн сийрүүлгэ, үсэг, үгийн галиг хийж зарим үгийн тайлбар, дурсгалд гарах үгийн толь хавсаргасан болно.

Хавсралтад цаашид нягтлан судлахад тус дэм болох үүднээс бичээс бүрийн дардасын болон эхийн гэрэл зургийг оруулав.

Бидний судалгааны ажилд алдаа эндэл, ташаа мадаг буй аваас шүүн үзэх мэргэд тольдон болгоож санал бодлоо харамгүй хайрлана уу.

Зохиогч

## УДИРТГАЛ

### 1.1. МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН СУДЛАЛЫН ТҮҮХЭН ТОЙМ

1. Монголын руни буюу Орхон-Енисейн бичгийн судлалын нэгдүгээр үе (1889-1910-аад он)
2. Монголын руни бичгийн судлалын хоёрдугаар үе (1950-1980-аад он)
3. Монголын руни бичгийн орчин үеийн судалгаа (1990-ээд ондоо хойши)

Монгол орны нэгэн гайхамшиг нь эртний үсэг бичгийн дурсгал бөгөөд монгол нутгаас брахми, согд, руни, уйгур, хятан, зорчин, монгол, нангиад, ланз, сири, араб, перс, төвд, самгарди, дөрвөлжин, тод, манж, соёмбо, вагиндра зэрэг олон зүйлийн үсэг бичгээрх гэрэлт хөшөө, хад чулууны бичиг дурсгал олныг үзэж болно.

Үсэг бичгийн хосгүй гайхамшигт тэдгээр сурвалжуудаас руни бичгийн дурсгал олдож илэрсэн тоо хэмжээ, бичээсийн утга агуулга, илэрхийлэх уран яруу өгүүлэмжээрээ онцгой ялгардаг.

Монголын руни бичгийн дурсгалыг анх хэн олж илрүүлсэн, хэрхэн уншиж судалсан талаар дотоод гадаадын эрдэмтдийн олон арван бүтээлд тодорхой тэмдэглэгдэж бичигдсээр иржээ.

Хэдийгээр тийм боловч Монголын руни бичгийн дурсгалын судалгааг гурван үе шатанд хуваан товч өгүүльв.

#### 1. Монголын руни буюу Орхон-Енисейн бичгийн судлалын нэгдүгээр үе (1889-1910-аад он)

Анх 1889 онд Николай Михайлович Ядринцев (1842-1894)-ийн удирдсан Оросын Газарзүйн Нийгэмлэгийн Дорнод Сибирийн салбарын шинжилгээний ангид Монгол оронд ирж Орхон голын хөндийд хосгүй хөшөө дурсгал буйг үзэж дэлхий дахинд мэдээлжээ<sup>1</sup>.

1890 онд Москва хотод болсон Олон Улсын Археологийн VIII Хурлын үеэр Н.М.Ядринцев Монгол нутаг Орхоны хөндийгээс эртний бичигт асар том, хөшөө дурсгал олсныг уг хуралд оролцсон Otto Donner (Otto Donner, 1835-1909), P.Aшпелин (Johan Reinhold Aspelin, 1842-1915) нар анх сонсож улмаар түүнийг судлан шинжилэх их эрмэлзэл оворлон буцаж Фин-Угорын нийгэмлэгээс A.Хейкел (Axel Olai Heikel, 1851-1924)-ээд удирдуулсан шинжилгээний ангийг 1890 онд Монгол оронд илгээсэн байна.

Археологич P.Ашпелин нь 1888 онд Минусинский музейд буй Енисейн бичээсийн дурсгалын хуулбар авч судлахаар ажилласан нэгэн байсан билээ. Тэрээр Монгол оронд ирж улмаар 1890 оны 8-р сарын 16-наас Көлтигин, Билгэ хаанд зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээсийн хувь дардас, хуулбар авсан гэдэг.

A.Хейкел асар холын замыг туулж олон гайхамшигт дурсгал үзсээр Иркутск, Томскоор өртөөлж 1891 оны 6 дугаар сард Хельсинкти буцаж хүрсэн байна. A.Хейкелийн удирдсан эл шинжилгээний ангийн ажлын үр дүнд Көлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээсийн хуулбар болон бусад дурсгалын гэрэл зургийг багтаасан цомог ном хэвлэгдэн гарчээ<sup>2</sup>.

<sup>1</sup> Н.М.Ядринцев, Предварительный отчет об исследованиях по р.Толе, Орхону и в Южном Хангайе, -Сборник трудов Орхонской экспедиции I, Санкт-Петербург, 1892, стр.27-40; Н.М.Ядринцев, Отчет экспедиции на Орхон, совершенной в 1889 г. Поручению Восточно-Сибирского Отд. Географического Общества, -Сборник трудов Орхонской экспедиции I, Санкт-Петербург, 1892; Н.М.Ядринцев, Отчет и дневник о путешествии по Орхону и в Южный Хангай в 1891 году, - Сборник трудов Орхонской экспедиции V, Санкт-Петербург, 1901, стр.1-54.

<sup>2</sup> A.Heikel, Inscriptions de L'Orkhon recueillies par l'expédition finnoise 1890, et publiées par la Société Finnoougrienne, Helsingfors, 1892.